

АРДЫН ХУВИЙН АЖ АХУЙТНЫГ ХОРШООЛОХ ҮЙЛ ЯВЦЫГ ЭРЧИМЖҮҮЛСЭН НЭГЭН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙ

Р.Төрдалай¹

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд МАХН-ын Төв хороо, Сайд нарын зөвлөлөөс 1951 оны 2 дугаар сард зохион байгуулсан нэгэн зөвлөгөөний тухай өгүүлэх болно. Энэхүү зөвлөгөөн дээр ардын үйлдвэрлэлийн нэгдлүүдийг төрөөс бодлогоор дэмжих, түүнд ардын хувийн аж ахуйтныг өмчийн хамтаар хэрхэн амжилттай татан оруулах тухайд нам, төрийн удирдагчдаас дэвшүүлсэн санаачлага болон санал зөрөлдсөн асуудлуудыг тодруулан гаргахыг зорив. Чингэж тодруулахын учир нь ХХ зууны Монгол орны нийгэм, эдийн засаг, соёлын салбарт үндсэн өөрчлөлт оруулсан ардын хувийн аж ахуйтныг хоршоолох бодлого эрчимжиж, амьдралд бодитоор хэрэгжихэд уг зөвлөгөөн үзэл санааны түүхэн нөлөөг үзүүлсэн билээ.

Түлхүүр үг: Нэгдэл, ардын хувийн аж ахуйтан, түүхт зөвлөгөөн, хоршоолох бодлого, онол-үзэл баримтлал, зарчмын санал зөрөлдөөн

1. Нэгдлүүдийг байгуулахын өмнөх бэлтгэл, судалгаа

1917 оны Оросын хувьсгалын дараагаар Евроазийн олон оронд нийтийн өмчийн талаарх ойлголт нэвтэрч эхэлжээ. 1920-иод оны сүүлчээр ЗХУ-д чинээлэг тариачдын хөрөнгийг хурааж, бүх тариачдыг хамтралд оруулан коммунизм байгуулах туршилт явуулсан ба энэ туршилт Төв Азийн орнуудад, тэр дундаа Монгол Улсад ч нэгэн адил явагджээ. Коммунизмын үзэл санааг түгээн дэлгэрүүлж, дэлхийг хувьсгалжуулах зорилго шинэхэн байгуулагдсан Коминтерний улс төрийн үндсэн ашиг сонирхол болж байв. Зөвлөлт засаг Ази тивд энэ зорилгоо хэрэгжүүлэхэд Монгол орон чухал түшиг газар болж байлаа.

¹ Р.Төрдалай, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн ЭША, докторант.

1921 оноос Зөвлөлт Оросын шууд дэмжлэгтэйгээр монголчууд төр засгаа эмхлэн байгуулж эхэлсэн үеэс ард нийтийн өмчит нийгэм байгуулах, хаад ноёд язгууртнууд, хутагт хувилгаад, баячууд зэрэг Монголын нийгмийн элит хэсгийг нийгмээс үе шаттайгаар шахан зайлуулах ажиллагаа эхэлсэн байна. 1922 оноос бүх хошуудаар хүн ам, мал хөрөнгийн дэлгэрэнгүй тооллого бүртгэл явуулж, нийгмийн элит давхаргын хүн бүл, хөрөнгийг нэг бүрчлэн бүртгэн авчээ. Түүндээ үндэслэн хожим язгууртнууд, баячуудыг устгах, хүчлэн хамтралд оруулж, малыг нь нийтийн өмч болгожээ.

ЗХУ-ын улс төр, эдийн засгийн бодлого, ашиг сонирхлын дагуу Оросын эрдэмтэн судлаачид 1921 оноос Монгол оронд ирж судалгааны ажил хийж байв. Тухайлбал, ардын хувийн аж ахуйтныг хоршоолохын өмнө Монгол орны хүн ам, мал аж ахуйн байдал, газар зүй, ургамалжилт, бэлчээр ашиглалтын судалгааг анхлан хийж, судалгааны тайлан бичсэн эрдэмтэд бол Зөвлөлтийн М.И.Майский², А.Д.Симуков³ нар юм. Тэдний судалгаа, тайлан нь Монгол орны бараг бүх аймгийг хамран өргөн хүрээнд хийгдсэн, өнөөдөр ч үнэ цэнэ нь буурахгүй судалгааны эх сурвалж болсоор байна.

1940-өөд оноос дээрх судалгааг үргэлжлүүлэхээр ЗХУ-аас суурин экспедици хүрэлцэн ирж, судалгааг улам өргөжүүлэн явуулахын зэрэгцээ ардын үйлдвэрлэлийн нэгдлүүдийг Монгол оронд байгуулах тухайд холбогдох бэлтгэл ажилд давхар анхаарлаа хандуулсан байна.⁴

Нэгдлүүд байгуулагдахаас өмнөх 10 жилийн түүхийг эргэн харвал ядуу, ядуувтар амьжиргаатай хэсгийг төрийн зохицуулалтаар дэмжиж, амьжиргааны хувьд дундаж хэмжээнд хүргэх зорилтыг төрөөс тавьж байв. Энэ бодлогыг ядуу малчид талархан хүлээн авч байжээ.

2 А.И.Майский 1921 онд Эрхүү хотноо хэвлүүлсэн “Современная Монголия” хэмээх бүтээлдээ 1918 оны хүн ам, малын тооллогын статистик үзүүлэлт хийгээд тухайн үеийн монголчуудын нийгмийн байдалтай холбоотой түүхэн үнэтэй сурвалж болохуйц судалгааны тайлан, ажиглалт тэмдэглэлээ бичиж үлдээжээ.

3 А.Д.Симуков, Труды о Монголии (1934) и для Монголии, Том I, составители Юки Коногая, С.Баяраа, И.Лхагвасүрэн, *Senri Ethnological Reports-66*, Государственный музей этнологии Осака 2007, 976 p.

4 “Ардын үйлдвэрлэлийн нэгдлийн үлгэрчилсэн дүрэм, холбогдох судалгаа”, 1940, 124 хуудас, “1948 онд хөдөө аж ахуйн нэгдсэн шинжилгээний ажлыг явуулсан Зөвлөлтийн ШУА-ийн экспедицийн тайлан”, 64 хуудас, “Ардын үйлдвэрлэлийн нэгдлүүдийг судалсан материал”, 1948, 819 хуудас, Үндэсний Төв Архив, Фонд №15, Данс-1, Хөдөө Аж Ахуйн Яамны архивын байнга хадгалагдах хадгаламжийн нэгжийн данс (1926-1960); Фонд № 1, данс – 4, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн фондын баримт материалын данс (1946-1950), Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архив, Фонд № 4, Данс-23-24; зэргээс үзнэ үү.

*Ардын хувийн аж ахуйтныг хоршоолох үйл явцыг
эрчимжүүлсэн нэгэн зөвлөгөөний тухай*

Анхны нэгдлийн хэлбэрүүд нь эхэн үедээ голчлон хөдөлмөрөө хамтарч эрхлэх сонирхол дээр суурилсан аж ахуйнууд байсан нь нэг талаар хамтралжуулах бодлогын завхралыг засах байдлаар Монголын хөдөө нутагт хамтын аж ахуйн “нэгдэл” гэдэг шинэ ойлголтыг оруулж ирэх зорилготой уялдсан байв.

Хамтралаас ялгаатай тал нь эдгээр нэгдлүүд нь 1932 онд баталсан *“Ардын үйлдвэрийн нэгдлийн тухай дүрэм”*-д заасанчлан өмчийн талаар хувь нийлэхгүй бөгөөд харин хөдөлмөрөө хоршин ажиллахад чиглэж байжээ. Хөдөө аж ахуйн хоршооллын эрхзүйг судалсан эрдэмтэд 1928-1930-аад оны эх хүртэлх үеийг “Хөдөлмөрийн харилцан туслалцах энгийн нөхөрлөлийн үе” гэж нэрлээд үүний дараа “Ардын үйлдвэрлэлийн нэгдлийн үе” эхэлж, 1950 оны дунд үе хүртэл үргэлжилснийг бүтээлдээ тэмдэглэсэн нь тухайн цаг үеийг бодитой үнэлсэн дүгнэлт юм.⁵

1939 онд баталсан *“Ардын сайн дурын үйлдвэрлэлийн нэгдлийн баримтлан дагаж явах дүрэм”*-д нэгдлүүдийн дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тодорхой тусгаж, малчдыг нэгдэлд сайн дурын үндсэн дээр элсэх боломжийг улам бүр нээлттэй болгожээ. Ингэснээр ардын үйлдвэрийн нэгдэл 1933 онд 50 байсан бол 1934 онд 56, 1939 онд 87 болж аажмаар нэмэгдсэн байлаа. 1940 он болоход мал хариулан адгуулах нэгдэл 49, хадлан эрхлэх нэгдэл 27, тариалан тарих нэгдэл 11 ажиллаж байжээ.⁶

Х.Чойбалсан төрийг барьсан жилүүдэд ардын үйлдвэрлэлийн нэгдэл болон ардын хувийн аж ахуйтнуудын малаа өсгөх сонирхлыг адил хэмжээнд дэмжин анхаарч байв. Ийнхүү хувийн аж ахуйтныг өмчийн хамтаар улсад хоршоолон нэгтгэх (хамтралжуулах бодлогыг оруулан тооцвол) үйл явц завсарлагатайгаар 30 шахам жилийг хамран үргэлжлэхдээ тухайн цаг үе бүртээ түүхэн өвөрмөц өнгө, онцлог шинжтэй явагдсан байна.

⁵ Б.Баярсайхан, “Хоршооллын эрх зүйн хөгжил”, Монголын төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага, Улаанбаатар 2003.

⁶ Үндэсний Төв Архив, Фонд-15, данс-1, хадгаламжийн нэгж-180, (Ардын үйлдвэрийн нэгдлийн үлгэрчилсэн дүрэм, холбогдох судалгаа, 1940.) 124 хуудас. Энд ардын үйлдвэрлэлийн нэгдлийн үлгэрчилсэн дүрмээс гадна 1940 оны байдлаар БНМАУ дахь нийт нэгдлүүдийн холбогдох судалгаа, тэдгээр нэгдлүүдийн гишүүдийн тоо, тэдний аж ахуй (өрх ам, мал хөрөнгийн тоо гэх мэт), нийгмийн байдлын тухай дэлгэрэнгүй тайлан мэдээг аймаг, сум, баг тус бүрээр тодорхой дурдсан байна. (P.T)

1940 онд хуралдсан МАХН-ын X их хурлын түүхэн ач холбогдлыг өнгөрсөн түүх бичлэгт онцгойлон тэмдэглэсээр ирсэн боловч жирийн малчдын амьдрал дээр илүү их хариуцлага, ачаа үүрүүлсэн, өөрөөр хэлбэл Монголын ард түмэн дундаж хэмжээнд амьдрахын тулд улам их хөлс, хүчээ гаргах шаардлагатай болсныг тунхагласан хурал болж өнгөрчээ.

Энэхүү Их хурлаар баталсан Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид ардын үйлдвэрлэлийн нэгдлүүдийг бэхжүүлэх, ардын хувийн аж ахуйтныг улс төр, үзэл суртал, эдийн засаг, эрхзүйн талаар “нийгмийн шахаа”-нд оруулах заалтууд тусгагдсанаар энэхүү үйл ажиллагаа улс орон даяар албан ёсоор эхэлсэн байна.

Тухайлбал, хоршооллын байгууллагууд ба ардын нэгдлүүдийн нийгмийн газрууд нь бүх тоноглол, багаж хэрэгсэл, ардуудын сайн дураараа нэгдэж хуримтлуулсан хөрөнгө хогшил, мал, нийтийн барилга байгууламжуудын хамтаар улсын өмч буюу нийт ардын хөрөнгө байх тухай уг Үндсэн хуульд тусгажээ.⁷

Түүнчлэн малын бэлчээр, тариалангийн газрыг ард иргэд, хөдөлмөрчдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдсан нэгдлүүдэд үнэ төлбөргүйгээр олгож, нийгмийн өмч байх заалт мөн. Үндсэн хуулинд орсон байна.

Үүнээс өмнө Монголын ард түмэн бэлчээрийн мал аж ахуйн уламжлалын дагуу говь, хангайн бүсийг дамнасан холын отор нүүдэл хийх боломжтойгоор газрыг харьцангуй чөлөөтэй байдлаар ашиглаж байсан бөгөөд энэ тухайд дотоод, гадаадын эрдэмтэд судалгаандаа дурдсан нь нэлээд бий.⁸

Гэтэл дээрх заалтуудын дагуу нэгдлүүдэд газрыг хуваарилж өгсөнөөр энэхүү уламжлалт байдал аажимдаа алдагдаж мартагдсан байна.

Тухайн үед төр засгаас энэ мэтчилэн ардын үйлдвэрлэлийн нэгдлүүдийг дэмжсэн олон талт бодлого үйл ажиллагаа явуулж, эрхзүй, татварын таатай орчныг бүрдүүлэх талаар анхаарч байв. Гэсэн

7 БНМАУ-ын Үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхэтгэл, 1940-1970, Боть II, Улаанбаатар, УХГ, 1974.

8 Maria E. Fernandez-Gimenez, “Sustaining the Steppes: A Geographical History of Pastoral Land Use in Mongolia”, *Geographical Review*, Vol. 89, No. 3 (Jul., 1999), pp. 315-342.

*Ардын хувийн аж ахуйтныг хоршоолох үйл явцыг
эрчимжүүлсэн нэгэн зөвлөгөөний тухай*

1940-1950 оны үе бол ардын хувийн аж ахуйтны өмчийг улсад нэгтгэх, ардуудыг улсын ажилчин болгох кампанит ажил хүчлэн хийгдээгүй харьцангуй намжмал үе байлаа.

Учир нь Дэлхийн II дайн дэгдэж, олон улсын байдал нэн түгшүүртэй болсон, БНМАУ-ын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал ЗХУ-аас шууд хамааралтай болсон (1939 оны Халх голын дайны жишээгээр), Герман улс ЗХУ-д халдан довтолж, дэлхийн дайн хөрш ЗХУ-д өрнөж, “Бүхнийг ялалтын төлөө”, “Бүхнийг фронтод” гэсэн уриалга бүхий Зөвлөлтийн ард түмэнд туслах хөдөлгөөн Монгол орон даяар өрнөснөөр малын тоог өсгөх, малаас гарах ашиг шим түүхий эдийг эрс нэмэгдүүлэх, ЗХУ-ын аж ахуйн найдвартай ар тал болох үүргээ нэр төртэй биелүүлэх шаардлага Монголын төр засгийн өмнө тулгарсан юм. Харин мал аж ахуйн өмчлөлийн асуудал улсад байх уу эсвэл ардын хувийн аж ахуйтнуудад хэвээрээ үлдэх үү гэх асуудлыг үндсэндээ түр хойш тавьсан байв.

2. Нэгдлүүдийг байгуулах, дэмжих бодлого дахин сэргэсэн нь

Дэлхийн II дайны дараах Монгол орны нийгэм, эдийн засгийн түүхийг судалсан зарим судлаачдын бүтээлд дурдан буй үеийн Монголын хөдөө аж ахуйг хөгжүүлэх стратеги, үзэл концепцийн талаар Х.Чойбалсангийн баримталж байсан үзэл санаа нь Ю.Цэдэнбал тэргүүтэй залуу удирдагчдаас⁹ зарчмын хувьд ялгагдахаар байсныг өгүүлсэн байдаг.¹⁰

Х.Чойбалсан “малчдыг хүчээр хамтралжуулж, мал сүргийг нь хураан авсан 1930-аад оны гашуун туршлагыг давтахгүй байх”-ыг эрмэлзэж байжээ. Энэ байдал нь Дэлхийн II дайны дараа Монголын нам, төрийн зарим удирдлагын зүгээс хоршоолох хөдөлгөөнийг удаашруулж байна гэх яриаг ч сэм дагуулж байв.¹¹

Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нар нь 1950-аад оны эхээр Монгол орныг цаашид хөгжүүлэх онол, үзэл баримтлалын талаар зарчмын

9 Ц.Гүрбадам, Ю. Цэдэнбал: Түүхэн үнэний тухай бодрол (Элчин сайдын дурсамж), Улаанбаатар 1994, 264 тал; Ц.Жамбалсүрэн., Ю.Цэдэнбал: Ард түмэндээ хүргэх үнэн өчил, Улаанбаатар 1996, 136 тал; Ю.Цэдэнбалаас П. Очирбаг хүртэл, Улаанбаатар 2000, 136 тал.

10 Д.Төмөртоого, “Чойбалсангийн эдийн засгийн үзэл санаа”, Acta Mongolica, vol. 4(236), Улаанбаатар 2005, 195-202 дугаар тал.

11 Д.Балжинням, Миний үе (Дурсамж), Улаанбаатар 1994, 24 дугаар тал.

зөрчилдөөнтэй байх болжээ. Ю.Цэдэнбал БНМАУ-ын нам, төрд өөрийн адил ЗХУ-д сургууль төгссөн, Зөвлөлтөд элэгтэй хүмүүсийг олноор дэвшүүлж, өөрийн тойрон хүрээллийг буй болгосон байна.

Тэд БНМАУ-ыг ЗХУ-ын дагуул улс болгох, Монголын хөдөө аж ахуйг социалист ёсоор хоршоолж дуусгах, ингэснээр тус улсад хувийн өмчийг бүрэн устгах, аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэн ажилчин ангийн шинэ давхарга буй болгох, монгол бичгийг халж, орос кирилл бичиг нэвтрүүлэх зэрэг марксист-ленинист онолд суурилуулан уясан олон санаачлагуудыг дэвшүүлэн гаргаж байв. Дээрх мэт олон санаачлагын зарим нь амьдралд бодитоор хэрэгжсэн явдлыг бид бэлхнээ мэдэх билээ.

Х.Чойбалсан Дэлхийн II дайны дараагаар БНМАУ-ын тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэхийн зэрэгцээгээр Ар, Өвөр Монголоо багтаасан Нэгдсэн Монгол улсыг байгуулах том амбицтай байсан юм. Харин 1950 оны Зөвлөлт-Хятадын хэлэлцээрийн дараа түүний энэхүү бодол нь талаар болж, Зөвлөлтөд ихээхэн итгэл алдарсан байдалтай хандах болсон тул¹² социализм байгуулах тухай онолын “мөрөөдөл”-д утопи гэх байдлаар хандаж, төдийлөн ач холбогдол өгөхгүй байсан бололтой.

Иймээс тэрээр нэгэн удаа “... Монгол Улсад социализм байгуулахад тусгаар тогтнол огтхон ч саад болохгүй” хэмээн ЗХУ-д төгссөн нам, төрийн залуу удирдлагуудад хандан онцгойлон анхааруулж байжээ.¹³

Тухайн үед Ю.Цэдэнбал тэргүүтэй сэхээтнүүдийн хамгийн их ач холбогдол өгч, анхаарал хандуулж байсан асуудлын нэг бол малчдын хувийн өмч болох мал сүргийг хоршоолох замаар улсын мэдэлд төвлөрүүлэх явдал байв. Монгол оронд социализм байгуулахад хамгийн шийдвэрлэх нөлөө үзүүлэх учиртай байсан хоршоолох бодлогын хэрэгжилтэд өмнө боловсруулан мөрдөж байсан ардын үйлдвэрлэлийн нэгдлийн дүрэм нийцэхгүй болж, учир дутагдалтай зүйл их байгаа тухай энэ үеэс яригдах болжээ.

¹² Sergey Radchenko, “Choibalsan’s Great Mongolia Dream”, *Inner Asia*, Vol. 11, No. 2 (2009), pp. 231-258.

¹³ Маршал Х.Чойбалсан: Тусгаар тогтнолоосоо ухрахыг Монголын түүх, ард түмэн, эцэг өвгөдийн номлол, сургаал хэзээ ч зөвшөөрөхгүй, Гадаад харилцааны яамны сайд агсан Н.Лхамсүрэн Ерөнхий сайд Х.Чойбалсантай уулзаж ярилцсанаа тэмдэглэн авчээ. Улсын архивын ерөнхий газрын дарга Д.Өлзийбаатар Н.Лхамсүрэн гуайг амьд ахуйд нь 1989 онд уулзаж Маршалын ярианы тэмдэглэлийг уншуулж, хуурцагт бичиж авсан байна. ТЕГ-ын тусгай архивт хадгалж буй.

*Ардын хувийн аж ахуйтныг хоршоолох үйл явцыг
эрчимжүүлсэн нэгэн зөвлөгөөний тухай*

Иймээс нам төрийн удирдлагууд Ардын үйлдвэрлэлийн нэгдлийн үлгэрчилсэн дүрэм"-ийн төлөвлөгөөг боловсруулах Комиссын анхдугаар хуралдааныг 1951 оны 11 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд хуралдуулж, бүх аймгийн хөдөө аж ахуйн нэгдлүүдийн төлөөлөгчдийг оролцуулан тэдний санал, зөвлөгөөг авсан томоохон хэлэлцүүлгийг явуулсан байна. Энэ бол МАХН-ын Төв хороо, Сайд нарын зөвлөлөөс хоршоолох бодлогын хэрэгжилтийг дуусгах, стратеги зорилгоо хэрэгжүүлэх үйл явцын эхлэл байсан билээ.¹⁴

3. 1951 оны түүхт зөвлөгөөн

Улс орныг бүрэн хамарсан дээрх хэлэлцүүлэгийн өмнөхөн БНМАУ-ын Ерөнхий сайд, маршал Чойбалсангийн өрөөнд 1951 оны 2 дугаар сарын 13-нд болсон зөвлөгөөн дээр хөдөө аж ахуйн нэгдлийн үлгэрчилсэн дүрмийн төлөвлөгөөг нарийвчлан хэлэлцсэн байна.

Энэхүү зөвлөгөөнд Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал, Г.Бумцэнд, Ч.Сүрэнжав, Д.Дамба, О.Жамбалдорж, Б.Ширэндэв, Н.Лхамсүрэн, С.Сосорбарам, элчин сайд Г.И.Иванников, С.П.Волокаников, С.Лувсан, Д.Майдар, Лувсанцэрэн, Шарав, Балжинням (Мал аж ахуйн яамны сайд), Сэнгээ (Мал аж ахуйн яамны сайдын орлогч), Чойжил (Мал аж ахуйн яамны Нэгдлийн хэлтсийн дарга), Резипов (Мал аж ахуйн яамны сургагч) нар оролцжээ.

Тус зөвлөгөөн нь мал аж ахуйн яамны мэргэжилтэн нар орос хэлээр зохиож ирүүлсэн хөдөө аж ахуйн нэгдлийн үлгэрчилсэн дүрмийн төлөвлөгөөг урьдчилан хэлэлцээний үндсэн дээр өөрсдийн саналыг гаргах зарчмаар явагдаж, нам, төрөөс цаашид хоршоолох бодлогын талаар явуулах үйл ажиллагааны үндсэн концепцийн шинжтэй асуудалд голлон анхаарлаа хандуулсан байдаг.¹⁵

Зөвлөгөөн дээр үг хэлсэн хүмүүсийн байр суурийг дор толилуулбаас:

Жамбалдорж: “... Шинээр төлөвлөж байгаа дүрэм нь одоогийн мөрдөж байгаа дүрмийг бодвол нэлээд давшилттай бөгөөд ардын

¹⁴ Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архив, Фонд-4, Данс-18, Хадгаламжийн нэгж-237, 216-243 дугаар хуудас.

¹⁵ Мөн тэнд

хүсэл эрмэлзлэлтэй нийцэж байна гэж үзнэ. Малыг нэгтгэх хэмжээг 20-50 хувиар тогтоох саналтай байна.”¹⁶

Лувсан: “...Малыг нэгтгэх хэмжээг 20-30 хувиар тогтоохоос гадна хувийн аж ахуйд үлдээх малын тухай энэ дүрэмд дурдахгүй орхивол дээр гэж үзнэ. Нэгдэлд орсон ард нь хөдөлмөрлөх бололцоо олох ба мөн хөдөлмөрлөсний хэмжээгээр ашиг олзыг олохоос өөр ямар ашигтай болохыг дүрмийн дотор дурдсан зүйл үзэгдэхгүй байна. Нэгдэлд ороход ашигтай зүйл байдаг юм бол түүнийг дүрмийн дотор онцлон тэмдэглэх нь чухал гэж би үзнэ.”¹⁷

Майдар: “... Улсад тушаах албан журмын үүрэг ба малын тоо толгойг заавал өсгөх улсын төлөвлөгөөнөөс зайлсхийсэн зарим нэгэн чинээлэг этгээдүүд нь нэгдэлд орохгүйгээр өөрийн малыг нэгдэлд өгч өөрийн биеэс зайлуулахыг хүсдэг байна. Ийм үл бүтэх хүмүүсээс малыг хүлээж авахгүй байх ба тэд нарт цохилтыг өгөх хэрэгтэй юм. ... Зөвлөлт улсын хамтралын байдал ба амьдралтай танилцах зорилгоор нэгдлийн гишүүдээс Зөвлөлт улсад экскурсээр явуулж сонирхуулан үзүүлж байх нь их чухал юм. Нэгдлийн гишүүдийн хувьд үлдэх малын тухай сайтар бодож төлөвлөх хэрэгтэй байна. Малын төрлийн талаар тохирохгүй явдлууд байж болох бөгөөд энэ явдлыг анхаарах нь чухал юм. Нэгдэлд нэгтгэх малын хэмжээг 10-20 хувиар тогтоовол хангалттай гэж үзнэ.”¹⁸

Ширэндэв: “... Малыг нэгтгэх тухайд бол малын тооны хэмжээгээр өсгөх систем дээр хувь тогтоох нь зүйтэй гэж би үзнэ. Үүнд: Малын тоо олон болох тутам нэгтгэх процентыг нэмэгдүүлэх хэрэгтэй болно. Чингэхгүй бол чинээлэг ардууд нь нэгдэлд орохдоо цөөн тооны малыг нэгдэлд нэгтгээд малын ихэнх хувийг хувьдаа үлдээж аваад хувийнхаа аж ахуй дээр үргэлж ажиллаж байхад хүрнэ. Нэгдэлд орж байгаа малын тоо нь дүрмэнд заасан малын тоонд хүрэхгүй бол тэр ардууд нь ерөөсөө нэг ч малыг нэгтгэхгүй байж болно гэж энэ дүрмийн төлөвлөгөөнд оруулбал зүгээр гэж бодож байна. Нэгдэлд орсон ардыг бүх гэр бүлээрээ орсон гэж үзэх хэрэгтэй байна. Үүнээс гадна нэгдлийн гишүүн бүхний ажиллавал зохих хөдөлмөрийн өдрийн

16 Мөн тэнд

17 Мөн тэнд

18 Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архив, Фонд-4, Данс-18, Хадгаламжийн нэгж-237, 216-243 дугаар хуудас.

*Ардын хувийн аж ахуйтныг хоршоолох үйл явцыг
эрчимжүүлсэн нэгэн зөвлөгөөний тухай*

тоог тогтоох нь хэрэгтэй байна. Нэгдлийн гишүүн нь жилд 60-70 хоног буюу барагцаалбал 2 сарын хугацаанд нэгдэлд заавал хөдөлмөрлөх тухай тогтоох саналтай байна. Хөдөлмөрийн зохион байгуулалтын тухай зүйлд бригадуудын үүргийн тухай авах нь зүйтэй. Нэгдлийн гишүүдийн хувьд үлдэх малын тухай сайтар бодож төлөвлөх хэрэгтэй байна. Малын төрлийн талаар тохирохгүй явдлууд байж болох бөгөөд энэ явдлыг анхаарах нь чухал юм. Нэгдэлд нэгтгэх малын хэмжээг 10-20 хувиар тогтоовол хангалттай гэж үзнэ.”¹⁹

Дамба: “... Малыг 25 хувиас доошгүйгээр нэгтгэх нь зүйтэй гэхээс гадна түүнээс дээш хэмжээгээр нэгтгэх явдлыг хүмүүсийн тус бүрийн сайн дурын хэрэг болговол зүйтэй юм гэж үзнэ. Малыг нэгтгэх явдал нь бүх малууд дээр холбогдох ба мөн үржлийн ба албаны малд нэгэн адил холбогдвол зохино. Газрын тухай бүлэг нь тохиромжгүй бичигджээ. Үүнд, нэгдлийн бүх гишүүдийн хурал нь газрыг нэгдэлд олгох тухай аймгийн Бага хурлын тэргүүлэгчдэд шаардлага тавьсан чанартай бичигдсэн байна.”²⁰

Сүрэнжав: “... энэ дүрмийн төлөвлөгөө нь манай онцлог байдлын шинжтэй холбогдсон онцгой ялгавартай талаа харгалзсангүй юм байна. Төлөвлөгөөний дотор хөдөө аж ахуйн нэгдлийн зорилго ба үүргийн тухай бараг юу ч дурдаагүй байна. Гэхийн зэрэгцээгээр Зөвлөлт Улсад хамтралыг байгуулсны 20 жилийн туршлагыг бид нар өмнөө харж байгаа учир ардын хөдөө аж ахуйн нэгдлүүдийг хөгжүүлэх ба бэхжүүлэх явдал нь манай улсыг социализмд оруулах тухай хамгийн зөв бөгөөд шууд зам мөн гэдгийг бид нар тодорхойгоор ойлгож байгаа.”²¹

Ю. Цэдэнбал: “... Энэ өдөр бидний хэлэлцэж байгаа асуудал бол тун гүнзгий зарчим бүхий асуудал болно. Үнэн хэрэг дээрээ та бид нар манай улсад социализмыг байгуулах тухай асуудлыг хэлэлцэж байна. Манай улс нь хоёр дахь хувьсгалынхаа өмнө зогсоод байна. Социализмыг байгуулах гэгч нь хувьсгалыг хийх гэсэн үг юм. Манайд улсад социализмыг байгуулах гэгч нь юу вэ гэж асуувал та бүхний өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудлыг шийдвэрлэн хэрэг дээр нь

19 Мөн тэнд

20 Мөн тэнд

21 Мөн тэнд

биелүүлэх гэсэн хэрэг мөн юм. Энэ нь манай улсын одоогийн хөгжлийн үед шатанд тус улсын өмнө зогсож байгаа улс төрийн гол зорилго мөн болно. Аяндаа явж социализмд орж болохгүй. Социализмыг зөвхөн ухамсартайгаар байгуулах болно. **Ардын нэгдлүүдийг байгуулснаараа нам нь социализмыг байгуулах оосрыг барьж байгаа хэрэг юм.** Манай нам нь энэ оосрыг барьж социализмыг байгуулахын тул тэмцэж байгаа явдал нь нам өсч, эрэлхэг чадвартай болж бэхжиж байгааг үзүүлж байгаа хэрэг юм. Одоо нэгдлүүдийг элдэв талаар хүч ба хөрөнгийг хайрлахгүйгээр дэмжиж бүх анхаарлаа нэгдлүүдэд хандуулах хэрэгтэй. Нэгдлүүд нь одоодоо их биш хүчтэй, тооны талаар цөөхөн байгаа боловч ямарваа нэгэн шинэ зүйл нь хөгжихдөө ялагдашгүй хүчтэй гэдгийг бид мэднэ. Тэр нь өөрийгөө хамгаалахын тул орилж чарлаж байгаа үедээ зогсож байна. Ийм учраас нэгдлийн хөгжилтийн замд тохиолдох ямар нэгэн саад бэрхшээлүүдийг шийдвэртэйгээр тас цохих явдал бид бүхний өмнө тулгарч байна. Мөн ард түмний дотор ялангуяа нэгдэлд юугаар яаж туслах ёстой юм бэ гэдгийг ухамсарлуулахын тулд улсын ба орон нутгийн засаг захиргааны байгууллагууд хийгээд нам, олон түмний байгууллагын ажилтны дунд бид хөдөө аж ахуйн нэгдлийн утга учир ба ач холбогдлын тухай өргөн танилцуулгыг хийх ёстой байна. Ардын тархай бутархай жижиг таваарын өмчийн аж ахуйгаас социалист маягийн гол аж ахуйд шилжин орж байгаа явдал бол нэг чанараас нөгөө нэг чанарт шилжин орж байгаа явдал мөн бөгөөд үүний үр дүнд одоогийн шинэ техник ба хөдөлмөрийн социалист арга методыг хэрэглэх бололцоог олно. Үүнд хүрэхийн тулд улсаас үргэлждийн хяналт шалгалтыг тавих ба зүйл бүрээр дэмжин туслах хэрэгтэй. Ийм учраас нэгдсэн аж ахуйг төлөвлөгөөтэйгээр хөтөлж явуулах, улсаас нэгдэлд тохирсон зөв төлөвлөгөө өгч байх явдал нь нэгдлийг хөгжүүлэн бэхжүүлэх хэрэгт асар их ач холбогдолтой болно.”²²

Элчин сайд Г.И.Иванников: “... Энэхүү дүрмийн төлөвлөгөөг нэгдлүүдийн одоогийн байдлаас салгаж болохгүй юм. Энэ дүрмийг баталсны дараа ардууд цөмөөрөө нэгдэлд орчих юм гэж би хэлж чадахгүй байна гэж нөхөр Сүрэнжаваас хэлсэн нь буруу болно. Үүнээс

22 Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архив, Фонд-4, Данс-18, Хадгаламжийн нэгж-237, 216-243 дугаар хуудас.

*Ардын хувийн аж ахуйтныг хоршоолох үйл явцыг
эрчимжүүлсэн нэгэн зөвлөгөөний тухай*

гадна энд гарч байгаа саналуудыг эмхтгэх ба үүний үндсэн дээр дүрмийн төлөвлөгөөний дотор бөглөгдөөгүй хоосон зайнуудыг бөглөх талаар зарим хүмүүст даалгавар өгөх хэрэгтэй байна. Өнөөдрийн ярианы 3 дугаар дутагдал бол зарим нөхдөөс хөдөлмөрийн өдөр гэж юу болох ба ер нь энэ асуудлын эдийн засгийн мөн чанарыг нь огт ойлгохгүй байгаа явдал болно. Ийм учраас хангай ба говьд янз бүр хөдөлмөрийн өдрийг тогтоох санал гарч байна. Хөдөлмөрийн өдрөөр биш бүтээх нормоор хэмжих ёстой. Жишээ нь, говьд 200 толгой мал хариулах, хангайд 300 толгой мал хариулах гэх мэт. Энгийн ардын аж ахуйтныг бодвол нэгдлийн гишүүн байх нь илүү ашигтай юм байна гэсэн тийм сонирхлыг нэгдлийн гишүүдэд төрүүлэхээр юм бодох хэрэгтэй гэж нөхөр Сүрэнжав тун зөв зүйлийг хэлсэн боловч түүнийгээ эцэс болтол тавьсангүй.”²³

Маршал Чойбалсан: “... Дүрмийн дотор бичигдсэн бүлгүүдийн зохион байгуулалтын дэс дараагийн хувь дээр бол зорилгын дараа үйлдвэрлэлийн хэрэгсэл, өөрөөр хэлбэл мал аж ахуйн бүлгийг оруулах нь зүйтэй юм гэж үзнэ. Газрын тухай асуудал дээр бол нэгдлийг заавал нэгэн багийн нутагт багтаан байгуулахаар дүрмийн төлөвлөгөөнд дурдсаны хэрэггүй. Харин нэгдлийн гишүүдээр багийг байгуулбал зүгээр юм гэж үзэж байна. Бид нэгдлийн ажлыг зохион явуулахдаа ардын ядуу аж ахуйтныг хамгийн өргөн хэмжээтэйгээр нэгдэлд оруулах явдлыг аль болохоор хичээх хэрэгтэй бөгөөд нэгдэлд элсэн орох бололцоог тэдэнд дүүрэн тавьж өгөх ёстой. Мал аж ахуйн нэгдлийн гол хүчин зүйл бол ядуу ба дунд ардын аж ахуйтан болох тул энэ дүрмийн агуулга нь ядуу, дунд аж ахуйтныг цөмийг нэгтгэхэд чиглэгдсэн байхын дээр тэдгээрийн ашиг сонирхлыг татахуйц бололцоо нөхцлөөр хангаж өгсөн байх хэрэгтэй. Үүний зэрэгцээгээр тус улсын аж ахуйтны дотор өчүүхэн бага суурийг эзэлж байгаа цөөн тооны дээд аж ахуйтнуудаас нэгдэлд орохдоо нэгтгэх хөрөнгийн хувийг дүрэмд ахиухан хэмжээгээр зааж өгч ч болох юм. Хэрэв нэгтгэх малын хувийг төдийгөөс дээш гэж дурдвал энэ доод хэмжээг нэмүүхнээр тогтоох нь зүйтэй байна. Нэгдлийн хөдөлмөрийн өдрийг хангай, говиор ялгаварласныг сайн хянаж үзэх хэрэгтэй байна. Тус дүрмийн дотор хүний дур сонирхлыг татахаар юм бараг алга байгаа тул үүнийг мөн анхаарах хэрэгтэй байна.

23 Мөн тэнд

Монгол улс нь мал аж ахуйн орон бөгөөд манай бусад ажиллагаанууд нь мал аж ахуйд туслах чанартай болох тул манай юм бүхэн дээр мал аж ахуйд өндөр суурийг эзлүүлэх хэрэгтэй бөгөөд мөн энэ дүрмийн дотор энэ зарчмыг нэгэн адил хадгалах хэрэгтэй болохыг би дахин давтан хэлье”²⁴ гэх зэргээр олон санал, шүүмжлэлийг гаргажээ. Энэхүү түүхэн хэлэлцүүлгийн дараа хөдөө аж ахуйн нэгдлийн талаар явуулах бодлогыг ЗХУ-ын социалист аж ахуйн үлгэрээр, шинжлэх ухааны арга зүйн үндэслэлтэй хөтлөн явуулах тухайд голлон анхаарах болсон байна.

Зөвлөгөөний хэлэлцүүлгийн дараа МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1951 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 23/42 дугаар хурлын тогтоолоор “Ардын үйлдвэрлэлийн нэгдлийн дүрмийн төлөвлөгөөг боловсруулах комиссыг байгуулах тухай” шийдвэр гаргаж, Х.Чойбалсангаар даргалуулан 27 хүний бүрэлдэхүүнтэй баталсан ба дээр дурдсанчлан нэгдлийн бүх гишүүдийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлжээ.²⁵

Нэгдлийн үлгэрчилсэн дүрмийн төлөвлөгөөг хэд хэдэн хувилбараар бодож боловсруулсан бөгөөд энэ бүхний үр дүнд БНМАУ-ын хөдөө аж ахуйн нэгдлүүдийн тэргүүний сайчуудын Анхдугаар их хурал хүлээн авч БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл ба МАХН-ын Төв хороо 1955 оны 3 дугаар сард баталсан “Ардын хөдөө аж ахуйн нэгдлийн үлгэрчилсэн дүрэм” батлагдсан байна. Энэ дүрэм нь тухайн үеийн Монгол орон дахь хөдөө аж ахуйн хоршоолох үйл явцад шийдвэрлэх нөлөө үзүүлсэн юм.

Хоршоолох бодлогын эрчимжилтийн эдгээр жилүүд дэх дээрх хэлэлцүүлэг, зөвлөгөөн, тогтоол, шийдвэрүүд бүгд нарийн судалгаатай (ЗХУ-ын мэргэжилтнүүдийн шууд оролцоотой) явагдаж байсан ба нам-төрийн удирдлагуудын зүгээс ч эл асуудал дээр ихээхэн хүч хаяж оролцжээ.

24 Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архив, Фонд-4, Данс-18, Хадгаламжийн нэгж-237, 216-243 дугаар хуудас.

25 Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архив, Фонд-4, Данс-18, Хадгаламжийн нэгж-2, 89-91 дүгээр хуудас.

4. Зөвлөгөөнийг дэмжсэн бусад шийдвэр

МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1952 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн хурлаас 70/135 тоот тогтоол гаргаж, *Тус улсын ирээдүйн хөгжлийн асуудлууд дээр ажиллахад зориулж, нөхөр Цэдэнбалд долоо хоногт 2 хоногийг гаргаж өгөх тухай*” шийдвэрлэсэн байна. Тогтоолд дурдахдаа:

”Одоо үед Бүгд Найрамдах Монгол Ард Улсын өмнө аж ахуй, улс төрийн чухал зорилгууд, тухайлбал ардын үйлдвэрлэлийн нэгдлүүдийг аж ахуй - зохион байгуулалтын талаар бэхжүүлэх, мал аж ахуйн талаар авч явуулах арга хэмжээнүүдийг боловсруулах, II таван жилийн төлөвлөгөөг зохиоход бэлтгэх зорилгууд зогсож байгаа ба түүнчлэн нөхөр Цэдэнбал үндсэн ажлаар маш их байгааг харгалзан үзээд энэ асуудлууд дээр ажиллахад зориулж, нөхөр Цэдэнбалд долоо хоногт 2 өдрийг тусгаарлан гаргаж өгөх нь зайлшгүй чухал гэж Улс төрийн товчооноос тогтов”²⁶ гэж заажээ.

Үүний зэрэгцээгээр МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1952 оны 8 дугаар сарын 7-ний өдрийн хурлын 74/158 тоот тогтоолоор “Ардын нэгдлүүдийг аж ахуй зохион байгуулалтын талаар бэхжүүлэх явдалд Шинжлэх ухааны хүрээлэнг татан оролцуулахаар мөн шийдвэрлэсэн байна.

Энэ тогтоолоор БНМАУ-ын газар зүйн үндсэн бүсүүдэд зарим нэгдлүүдийг сонгон тулгуур болгон авахыг Шинжлэх ухааны хүрээлэнд зөвшөөрч эдгээр нэгдлүүдийн үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндсэн дээр зохион байгуулж, тэдгээрийг ойрын жилүүдийн дотор үлгэр жишээ аж ахуй болгох, нэгдлүүд дээр тулгуурлан мал аж ахуй, газар тариалан, ургамал, хөдөлмөр зохион байгуулалтын ба бүртгэх талаар эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн туршлагын ажлуудыг зохион явуулах, Шинжлэх ухааны хүрээлэнд ардын нэгдлүүдийг аж ахуй, зохион байгуулалтын талаар бэхжүүлэхэд туслалцах группыг байгуулах, ардын нэгдлүүдийг аж ахуй, зохион байгуулалтын талаар бэхжүүлэх явдалд туслалцах, энэхүү группыг ардын нэгдлүүдийг аж ахуй, зохион байгуулалтын талаар бэхжүүлэх тодорхой арга хэмжээнүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх ажилд туслалцуулах тухай заажээ.

²⁶ Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архив, Фонд 4, Данс- 26, Хадгаламжийн нэгж 15, 299-300-р хуудас.

Уг группыг эдийн засагч Жагварал (Группын удирдагч), зоотехникч Аюурзана, ургамалч Дашням, агрохимич Бадарч, малын эмч Сугаррагчаа, инженер-гидрологич Чогдон, инженер-механикч Дорж нарын бүрэлдэхүүнтэйгээр баталсан байна.²⁷

Энэ дашрамд тэмдэглэхэд, хөдөө аж ахуй дахь газар зохион байгуулалтыг цаашид боловсронгуй болгох үүднээс тухайн үед эл асуудлаар үндэсний судалгааг явуулах нь нэн чухал байлаа.

XX зууны дунд үеэс манай үндэсний сэхээтнүүд Монгол дахь газрын харилцааны түүхийг анхлан судалж байсан юм. Үүнд Н.Жагваралын “Монгол дахь газрын асуудал”²⁸ хэмээх бүтээл чухал байр суурийг зүй ёсоор эзэлнэ²⁹. Мэдээж тэрбээр тухайн асуудалд марксист-ленинист арга зүйгээр хандсан боловч түүний судалгаа өдгөө ч үнэ цэнэтэй хэвээр Монголын газрын харилцааг судлагч хэн бүхний заавал үзэх бүтээл болохыг энэ завсар онцлон дурдъя.

1950-иад оны эхээс нэгдлийн мал аж ахуйд Зөвлөлтийн хамтын аж ахуйн туршлагыг өргөн хэрэглэх, шинжлэх ухааны боловсон арга ажиллагааг нэвтрүүлэх замаар малын үүлдэр, чанарыг сайжруулах, ашиг шимийн гаралтыг нэмэгдүүлэх, тариа ногоо тарих, жин тээх, ан агнах, барилга барих зэрэг ашиг орлого ихтэй ажил хийж, нийгмийн өмчийг арвижуулах тухай яриа хэлэлцээ МАХН-ын удирдлагуудын дунд хүчтэй яригдах болж, сонин хэвлэлээр ч нэлээд бичигдэж байв.³⁰

Мөн эдгээр шийдвэрийн дараагаар МАХН-ын Төв хорооны нарийн бичгийн дарга нарын 1956 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн зөвлөгөөний тогтоолоор ЗХУ-ын хамтралуудын практик туршлагатай танилцах зорилгоор Алтайн хязгаар, Буриад Монгол, Чита мужийн чиглэлээр хөдөө аж ахуйн нэгдлүүдийн 150 ажилтныг 1 сарын хугацаатайгаар явуулахаар баталсан байна.³¹

27 МАХН-ын Төв Архив, Фонд-4, Данс- 26, Хадгаламжийн нэгж-15, 341-342 дугаар хуудас.

28 Н.Жагваралын энэхүү гар бичмэл бол Монгол дахь газрын харилцааны түүхийг судлан үзсэн анхны судалгааны бүтээл мөн гэж бардаагаар хэлж болно. Өдгөө ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн Гар бичмэлийн сангийн 4-94-54-д хадгалагдаж байна. Зохиогч гар бичмэлдээ хувьсгалаас өмнөх газрын харилцааны холбоотой нугалбар бичиг, газрын зураг сэлтийг фото болгон хуулбарлан авч гар бичмэлдээ наан хавсаргасан байна. Энэхүү гар бичмэл нь нийт 125 тал ажээ.

29 na. jiyubara, mongol daki yajar-un asayudal(yar bicimel), bu.na.mo.a.ulun-un sinjilekui uqayan-u kuriyeleng, teuke-yin kabinet, ulayanbayatur, 1953, 125 tal-a.

30 Үнэн сонин, 1953.06.10; Үнэн, 1953.12.04.

31 МАХН-ын Төв Архив, Фонд-4, Данс- 26, Хадгаламжийн нэгж 15.

*Ардын хувийн аж ахуйтныг хоршоолох үйл явцыг
эрчимжүүлсэн нэгэн зөвлөгөөний тухай*

ДУГНЭЛТ

Энэ бүхнээс дүгнэлт хийхэд 1952 оноос Монгол оронд хоршоолох бодлогыг эрчимжүүлэх үйл явц дээрх зөвлөгөөн дээр Ю.Цэдэнбал тэргүүтэй нам, төрийн залуу удирдагчдаас гаргасан санал санаачлагын дагуу цаашид зураглагдан өрнөсөн байна. Учир нь 1952 оны 1 дүгээр сарын 26-нд маршал Х.Чойбалсан Москва хотноо эмчилгээ хийлгэж байгаад нас барсан тул Ю.Цэдэнбал тэргүүтэй ЗХУ-д бэлтгэгдсэн залуу улс төрчдөд зөвлөх, санал бодлоо илэрхийлэх, зарим үед шүүмжлэх, эсэргүүцлээ илэрхийлэх зориг зүрхтэй хүн Монгол орноос нэг хэсэгтээ дахин гарч ирээгүй байна.

Зөвлөгөөнд оролцогчдын хэлсэн үгүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд ардын үйлдвэрлэлийн нэгдэл болон ардын хувийн аж ахуйтны цаашдын хөгжлийн холбогдолтой асуудлаар Х.Чойбалсан болон Ю.Цэдэнбал нарын хооронд дараах хэдэн зарчмын ялгаатай байр суурь ажиглагдаж байна. Үүнд:

Х.Чойбалсангийн байр суурь	Ю.Цэдэнбал тэргүүтэй улс төрчдийн байр суурь
Нэгдлүүд болон ардын хувийн аж ахуйтныг адилхан дэмжиж байсан	Нэгдлүүдийг байгуулах нь улс төрийн гол зорилго болсон
Хамтралжуулах үйл явцын алдааг давтахгүй байхыг эрмэлзэж байсан	Ардын хөдөө аж ахуйн нэгдлүүдийг хөгжүүлэх ба бэхжүүлэх нь социализмд орох хамгийн зөв бөгөөд шууд зам гэж үзсэн
Ардын хувийн аж ахуйн талаар уян хатан бодлого баримталж байсан	Хувийн аж ахуйн талаар хатуу бодлого баримталж байсан
Нэгдлүүдийн үр ашгийг харгалзан үзэж, олноор байгуулахыг алгуурлаж байсан	Социализмыг ухамсартайгаар байгуулахад нэгдлүүдийг кампаничлан байгуулах, улсаас бүх талаар дэмжих нь чухал гэж үзэж байсан
Монгол орны онцлог, түүхэн өвөрмөц байдлыг хадгалах, анхаарахыг эрмэлзэж байсан	ЗХУ-ын хамтралуудаас туршлага судлахыг чухалчилсан

Нэгдлүүдийн газар бэлчээрийг сум, багийн нутгаар хязгаарлахгүй байхыг гол болгосон	Сум, багт газар зохион байгуулалт хийж, газар бэлчээрийг нарийвчлан хуваарлахыг гол болгосон
Ядуу, дунд ардуудын амьжиргааг дэмжих замаар тэднээс голчлон нэгдэлд оруулахыг зорьсон	Чинээлэг ардуудын малыг нэгдэлд ахиухан хэмжээгээр нийгэмчлэхийг зорьсон
Хангай, говиор ялгаж тогтоох нь зөв эсэхийг сайтар нягтлан судлахыг зааж байсан	Хангай ба Говьд хөдөлмөрийн өдрийг ялгавартай тогтоож, ажлын бүтээмжээр хэмжихийг санал болгосон
Дүрмийг засаж сайжруулах, өөрийн орны онцлогийг тусгах зүйл их байгааг хэлж байсан	Дүрэм сайн боловсруулагдсан гэж үзэж байсан

Дээрх зөвлөгөөний байдлаас харахад тухайн үеийн нам, төрийн удирдлагын дунд малыг нийгэмчлэх тухай асуудлаар цаг нь болсон эсэх, эл үйл явцыг хэрэгжүүлэх арга замын талаар зарчмын багагүй санал зөрөлдөөн байсныг харуулж байна. Тус зөвлөгөөнд ЗХУ-ын улс төрийн ашиг сонирхол бодитоор туссан нь элчин сайд энэ зөвлөгөөн дээр идэвхтэй үг хэлж, шүүмжлэл дүгнэлт хийж байснаас тодорхой харагдаж байна.

Ю.Цэдэнбал тэргүүтэй ЗХУ-д боловсрол эзэмшсэн улс төрчид хоршоолох бодлогыг эрчимжүүлэх талаар онолын дүгнэлт өгч, түүнийг бусад нь төдийлөн эсэргүүцэхгүйгээр аялдан дагасан байдал ажиглагдаж байна.

Хэдийгээр улс төр, эдийн засгийн онол, үзэл баримтлал бүхий ЗХУ-д талтай шинэ залуу бүлэг Монголын нам, төрийн тэргүүнд нэгэнт гарч бэхжсэн боловч маршал Х.Чойбалсангийн улс төрийн нөлөө, байр суур хадгалагдсан хэвээр байсан нь зөвлөгөөний үйл явцаас харагдаж байна. Тиймээс түүнийг насан эцэслэх хүртэл хоршоолох хөдөлгөөнийг шинэ залуу удирдагчид төдийлөн далайцтай явуулж чадаагүй байна.

Ю.Цэдэнбал тэргүүтэй ЗХУ-д боловсрол эзэмшсэн улс төрчид ардын тархай бутархай жижиг таваарын өмчийн аж ахуйг хоршоолох

*Ардын хувийн аж ахуйтныг хоршоолох үйл явцыг
эрчимжүүлсэн нэгэн зөвлөгөөний тухай*

замаар социалист маягийн аж ахуйд шилжүүлж, ингэснээр нэг чанараас нөгөө нэг чанарт шилжин орж байгаа тухай онолын дүгнэлт хийн үүний үр дүнд шинэ техник ба хөдөлмөрийн социалист арга зүйг хэрэглэх бололцоог олох тухай эрчимтэй ярьж байжээ.

Энэхүү зөвлөгөөн нь ХХ зууны Монгол орны нийгэм, эдийн засаг, соёлын түүхийг өөрчлөн хувьсгаж, гүнзгий ул мөрөө үлдээсэн, магадгүй өнөөдөр ч Монголын хөдөө аж ахуйн салбарт үр дүн нь мэдэгдсээр буй хоршоолох (нэгдэлжүүлэх) бодлогыг амьдралд бодитоор хэрэгжүүлэх (*ялалтад хүргэхэд –тухайн үеийн хэллэгээр*)-эд үзэл санааны чухал нөлөө үзүүлсэн байна.